

"Монгол савхи" ХК-ийн Хувьцаа Эзэмшигчдийн
ээлжит хурлын тэмдэглэл

2026.04.24

Улаанбаатар хот

"Монгол савхи" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 10.00 цагт "Монгол савхи" ХК-ийн хурлын танхимд хуралдлаа.

Хурлын дарга Г.Ганчимэг удирдах байсан боловч эрүүл мэндийн байдлын улмаас ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал Г.Мөнхбилэг хурлыг удирдан явуулах боллоо.

Хурлын дарга Г.Мөнхбилэг: Хурлын дэгийг танилцуулаад саналаа өгнө үү гэхэд Хуралд оролцогчдын 100 хувийн саналаар хурлын дэгийг баталлаа. Нарийн бичгийн дарга П.Мөнгөнцэцэг ирцийг танилцуулав.

"Монгол савхи" ХК-ийн хувьцааны 1,749,786 ширхэг хувьцааг эзэмшигч 70,69% хувьцаа эзэмшигч хуралд ирсэн ба 71 хувийн ирцтэй байна.

Г.Мөнхбилэг: Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дүгээр заалтыг үндэслэн ирц хангалттай гэж үзээд хурлыг эхлүүлж байна.

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

-Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлан

-Компанийн ТУЗ-ийн 2025 оны тайлан

-Аудитын хорооны тайлан

-ТУЗ-ийн гишүүдийг сонгох

Г.Мөнхбилэг: Компанийн үйл ажиллагааны тайланг нягтлан бодогч Ч.Тогтохбаяр танилцуулна. Үйл ажиллагааны тайланг танилцуулав. /Хурлын материалд тайланг хавсаргав. /

ТУЗ-ийн дарга Г.Ганчимэг өвчтэй байгаа тул ТУЗ-ийн тайланг Г.Мөнхбилэг танилцуулав. /Хурлын материалыг тайланд хавсаргав/

Г.Мөнхбилэг: Аудитын хорооны тайланг Ч.Тогтохбаяр танилцуулна.

Аудитын хорооны тайланг танилцуулав. /Хурлын материалд тайланг хавсаргав/

Г.Мөнхбилэг: За анх удаа хуралд сууж байгаа 2 хүн байна. Энэ 2 хүндээ компанийн ерөнхий байдлаа танилцуулья. 1996 онд анх хувьчлалын дараа савхин эдлэл үйлдвэрлэж байгаад сүүлдээ түүхий эдгүй болоод даавуун материал үйлдвэрлэж байсан боловч зах зээл муутай байсан учраас үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж чадахаа байгаад хятадуудад хэсэг түрээслэж байсан боловч тэд буцсан. Одоо бол бн давхараа оффисын чиглэлээр түрээслээд явж байна. Компанийн үйл ажиллагааг сайжруулья гэвэл ихээхэн хөрөнгө оруулалт хэрэг болно. Байшин барилгын хувьд олон жил болсон тул сантехникийн асуудлаас эхлээд муудсан байгаа. Жил болгон багахан шиг засвар, үйлчилгээг хийдэг. Доод давхруудад үйлдвэрийн том том заалнууд байдаг. Үүнийг түрээслэх гэхээр засвар үйлчилгээ шаардлагатай, Хувьцаа эзэмшигч хөрөнгө гаргаад засвар хийнэ гэхээр боломжгүй байдаг.

ХЭ Пүрэвсүрэн: Би 1991 онд хувьцаа авсан. Түүнээс хойш 1,2 удаа л ногдол ашиг авсан санагдаж байна. Санхүүгийн тайлан дээр харахад ашигтай ажилласан харагдаж байна. Ер нь хувьчилсанаас хойш ногдол ашиг өгөх өр үүснэ гэж байх уу. Г.Мөнхбилэг: Тухайн тухайн үедээ ногдол ашиг тараана, тараахгүй гээд шийд гараад явдаг. Ногдол ашиг хуримтлагдаад явна гэж байхгүй. Тухайн онд ногдол ашиг тараана гээд харин хувь хүн аваагүй бол ногдол ашиг нь байж байна л гэсэн үг. Энэ жилийн хувьд 17,817.6 мянган төгрөгийн ашигтай ажилласан ба энэ нь компанийн үйл ажиллагаанд зарцуулагдсан гэсэн үг. Одоогийн байдлаар байшингаа хөлдөөчихгүйн тулд дулаан, цахилгаанаа төлөөд, ажилчдаа цалинжуулаад л явж байна.

Пүрэвсүрэн: 1991 онд анх хувьчлагдахад хөрөнгө оруулалт хийсэн. Эзэн л гэсэн үг байх. Тодорхой хэмжээний хөрөнгө байгаа л гэсэн үг үү.

Г.Мөнхбилэг: Хөрөнгийн бирж дээр тухайн үеийн ханш ямар байна тэр ханшаар үнэлэгдэнэ. Сүүлийн 52 хоногийн дунджаар хувьцааны үнэлгээг гаргадаг.

ХЭ Янжмаа: 11 ажилчинтай байна. Савхин эдлэл хийдэггүй юмуу.

Г.Мөнхбилэг: Би түрүүн тодрхой ярьсан. 1990 ээд оноос хойш хэсэг ажиллуулж байгаад түүхий эд байхгүй, тоног төхөөрөмж муудсан, зах зээлгүй зэрэг шалтгаанаас савхин эдлэл хийх боломжгүй болсон.

Пүрэвсүрэн: Том хувьцаа эзэмшигчийг төлөөлж та сууж байгаан байна. Үндсэн үйл ажиллагаа явахгүй байна. Ирээдүйд яана гэж төлөвлөж байна.Цаашид үйлдвэрлэл болгох юмуу түрээслээд явах юмуу.

Г.Мөнхбилэг: Цаашид үйлдвэрлэл гэвэл худлаа. Монгол зах зээл байхгүй, үр ашиггүй болох байх. Нилээн хэмжээний хөрөнгө оруулалт хийвэл Мишээл ч юмуу Номин мэт үйлчилгээний чиглэлээр л болох байх. Оффисын чиглэлээр гэхээр орчин маань ямар билээ. Тэгэхээр үйлчилгээний чиглэлээр л явуулбал тохиромжтой байх. Ингэхийн тулд нэмэлт хувьцаа гаргаж байж л хөрөнгө оруулалтын асуудлаа шийдэх байх.

Пүрэвсүрэн: Улсын өмч байж байгаад хувьчлагдсан болохоор өмч байгаа гэж бодоод ер нь учрыг нь олъё гээд асуугаад байгаа юм. Сая Дарханы нэхийд очиж суусан. Бас л түүхий эд байхгүй гээд сууж байсан. Гэтэл арьс шир хөдөөгүүр зөндөө л байна. Гэтэл яг энэ чиглэлийн үйлдвэрүүд цаашид боломжгүй гээд яриад сууж байна. Төр засгийн буруу юм болов уу.

Г.Мөнхбилэг: Энэ бол зах зээлийн асуудал л даа. Борлуулалт байхгүй бол бид хичнээн түүхий эд аваад зах зээлгүй бол хэцүү шүүдээ.

ХЭ Лхагвасүрэн: Наадам болохоор арьс шир зөндөөл байдаг.

Г.Мөнхбилэг: Хятадууд л арьс ширний зах зээлийг мэдэж байна байна. Жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьд компани үйл ажиллагаа явуулаад ашиг олоод байгаа хэрнээ ногдол ашиг өгөхгүй байна гэж ойлгодог зүйн хэрэг байх. Том хувьцаа эзэмшигчид бас л хохирч байгаа. Цаашид том хувьцаа эзэмшигчдийн зүгээс тодорхой шийд гаргана лдаа. Цаашид яаж явах уу, ямар чиглэлээр явбал ашигтай байна гэдгийг судална.

Лхамсүрэн: Ерөнхийлөгчийн цагаан алт хөтөлбөрт хамрагдаж байсан уу.

Г.Мөнхбилэг: Үгүй хамрагдахгүй.

Пүрэвсүрэн: Харин тийм байна лэй. Дарханы нэхий бас хамрагдаагүй сарлагийн хөөвөр лүү орно гэж байсан. За маш ойлгомжтой танилцлаа. Баярлалаа.

Г.Мөнхбилэг: Өөр санал хүсэлт байна уу.

Янжмаа: Алгаа.

Г.Мөнхбилэг: 2026 онд ногдол ашиг тараахгүй гээд ТУЗ-ийн тогтоол гарсан байгаа.

Одоо санал шүүмжлэл дууслаа дэгийн дагуу ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийг танилцуулна.

НБДарга: ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч нарыг танилцуулав.

Г.Мөнхбилэг: Асуух асуулт байвал асуугаарай.

НБДарга: ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч нараас асуух асуулт байсангүй. Саналын хуудсыг тарааж өгөв.

Тооллогын комиссын саналын хуудсаар авсан тооллогын дүнгээ танилцуул.

Тооллогын комиссын дарга Д.Сүрэнхорлоо: Санал хураалтын дүнг тооллогын комисс нэгтгэж, тогтоолын төслийг танилцуулав.

Г.Мөнхбилэг: Хурлаас гарах тогтоолын төслийг танилцуулав.

1. Саналын хуудсаар компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлан, ТУЗ-ийн тайлан, Аудитын хорооны тайланг хувьцаа эзэмшигчид 100 хувь зөвшөөрсөн байна.

2. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч Г.Ганчимэг, Г.Мөнхбилэг, Д.Хуушаан, А.Цэцэгдэлгэр, Ч.Тогтохбаяр, Д.Мөнхсайхан, хараат бус гишүүн Г.Баттулга, Э.Мөнхсайхан, С.Ундармаа нарт 1,749,786 ширхэг санал буюу нийт 100 хувийн саналаар тус тус санал авсанг хуралд оролцогчид санал нэгтэй батлав.

Хурлын дарга Г.Мөнхбилэг: Монгол савхи" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолын төслүүдийг танилцуулж баталлаа.

1. Тогтоол №1 Тайлан батлах / 2025 оны үйл ажиллагааны тайлан, Аудитын хорооны тайлан, ТУЗ-ийн тайлан/

2. Тогтоол №2 ТУЗ-ийн гишүүдийг батлах

Хурлыг 11.20 минутанд хаав.

Хянасан Хурлын дарга

Г.Мөнхбилэг

Тэмдэглэл хөтөлсөн:

П.Мөнгөнцэцэг